



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/1/СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.dornogovi.audit.mn">www.dornogovi.audit.mn</a> Дорноговь аймаг 2020 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734      Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020      Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Ахлах аудитор: О.Нарангарав Утас: 70523020      Цахим хаяг: Narangarav.o@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө .....	7
2.8.2 Авлага.....	8
2.8.3 Бараа материал .....	8
2.8.4 Үндсэн хөрөнгө .....	9
2.8.5 Өр төлбөр.....	10
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	13
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	13
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	21
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	23
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	24

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан

## 1. Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2020-03-23 № 4-6/344  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА С.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020161

### Аудитын гол асуудал

1. Хатанбулаг сумын ЗДТГ нь 2019 онд тээвэр шатахууны зардлаас 24.2 сая төгрөгийн шатахуун, түлш халаалтын зардлаас 10.6 сая төгрөгийн түлш, Ай-Ти-Зоне ХХК-аас 12.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч бэлтгэхдээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна. Энэ нь Монгол улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлд заасан худалдан авах ажиллагааны зарчим, Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2019 оны 68 дугаар тогтоолыг зөрчсөн байна.
2. Хатанбулаг сумын ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансаар Си Өү Эй Эл ХХК-аас нийт 62.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Энэ нь НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага хандив тусламж авч болно”, 25.5-д “... хандив тусламж өгсөн этгээд төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх, байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Дээрх Хатанбулаг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд илэрсэн 110.1 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэл тайланд тооцон материалыг байдлын түвшингөөс 2.6 дахин давж байна.

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ТТЗ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Эрдэнэболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10-аас 2020 оны 03 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 05/135 дугаар бүхий албан бичгээр 2020 оны 03 дугаар сарын 12-ний өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорноговь аймгийн Санхүү төрийн сангаас боловсруулан гаргасан санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн

Хатанбулаг сумын ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019 онд харьяа орон нутаг дахь төсөвт байгууллага, сангийн 2017-2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, ТШЗ-ийн 6 байгууллага, 3 тусгай сангийн үйл ажиллагаанд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр нийт 82 зөвлөмж өгсөн байна.

#### **2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Хатанбулаг сумын ТТЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэл санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг цэвэр хөрөнгийн 4,138.7 сая төгрөгийн 1 хувь буюу 41.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 44.2 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үед материаллаг байдлыг 2019 оны хагас жилийн тайлангийн

дүнгээр сонгон авсан тул өөрчлөн жилийн эцсийн тайлангаар материаллаг байдлыг тодорхойлсонтой холбоотой.

## 2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сан, төсөвт байгууллагын 4 ахмадын сан, нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 төсвийн байгууллага 2 тусгай сан аудитад хамрагдсан байна. Төсвийн шууд захирагчийн 4 байгууллагад санал дүгнэлт өгөхөөр, тусгай сангийн 2, ТШЗ-ийн 2 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дараах дүгнэлтүүдийг өгсөн байна.

- “**Зөрчилгүй**” дүгнэлт - Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг
- “**Хязгаарлалттай**” дүгнэлт – сумын Засаг даргын тамгын газар

Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 518.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 403.6 сая төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулав.

Сумын ЗДТГ-ын 110.1 сая төгрөгийн зөрчил нь Хатанбулаг сумын ТТЗ-ийн нэгтгэл тайланд тооцон материалыг байдлын түвшингөөс 2.6 дахин их байгаа нь дүгнэлтэд нөлөөлж байна.

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 403.6 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- **СХС-ийн санхүүгийн тайланд:** Тайлант онд олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн тооцооллыг санхүүгийн тайлантай тулгаж үзэхэд 1.8 сая төгрөгийн хүү, алдангийг илүү тооцсон бүртгэлийг, мөн 60.1 сая төгрөгийн зээл олголтыг зардлаар хүлээн зөвшөөрч, өмнөх үеийн үр дүнд нэмэгдүүлэн бүртгэж тайлагнасан нийт 61.9 сая төгрөгийн 2 алдаануудыг залруулан бүртгэв.
- **Сумын Засаг даргын тамгын газрын тайланд:** холбогдох тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэж хаасан 185.9 сая төгрөгийн алдааг залруулан бүртгэсэн байна.
- **Ерөнхий боловсролын сургуулийн тайланд:** Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг бусад орлогоор бүртгэсэн 3.4 сая төгрөг, бараа материалын орлого, зарлагын гүйлгээг цаг тухай бүрд бүртгээгүй сарын эцэст орлого, зарлага гүйлгээг бүртгэсэн 108.3 сая төгрөг, тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн 7.3 сая төгрөг, үндсэн хөрөнгийн ангилал буруу хийсэн болон үндсэн хөрөнгөнд бараа материалыг бүтгэсэн 36.8 сая төгрөг, нийт 155.8 сая төгрөгийн 5 алдааг залруулан бүртгэсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн зөрчлийг нэгтгэн хавсралт 1-ээр үзүүлсэн болно.

## 2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 69.91 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 110.0 сая төгрөг болж, 40.1 сая төгрөгөөр буюу 57.3 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	69.91	109.96	40.06	57.30
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>69.91</b>	<b>109.96</b>	<b>40.06</b>	<b>57.30</b>

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байгаа 110.0 сая төгрөгийн 4.7 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 5.9 сая төгрөг нь ОНХС-ийн дансанд, 87.5 сая төгрөг нь СХС-ийн дансанд, 5.5 сая төгрөг нь байгаль орчны нөхөн сэргээх сангийн дансанд, 6.3 сая төгрөг нь 4 ТШЗ-ийн ахмадын сангийн дансанд тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь 2019 онд нэмэлт санхүүжилтийн дансаар Си Өү Эй Эл ХХК-аас нийт 62.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

## 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 169.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 131.2 сая төгрөг болж, 38.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.04	-	(0.04)
Төлбөртэй үйлчилгээний авлага	3.51	-	(3.51)
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	6.09	6.09	-
Бусад авлага	17.73	8.23	(9.50)
Зээлийн авлага	141.95	116.84	(25.11)
<b>Дүн</b>	<b>169.32</b>	<b>131.16</b>	<b>(38.16)</b>

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 38.2 сая төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага болон бусад авлага 13.1 сая төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 25.1 сая төгрөгөөр тус тус буурсан нь шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 122.9 сая төгрөг нь СХС-ийн зээлийн авлага, 3.9 сая төгрөг нь Цэцэрлэгийн албан хаагчидтай холбоотой авлага байна.

Харьяа ТШЗ-ийн 4 байгууллагад 2008 онд үүсэн 4.6 сая төгрөгийн авлагыг Дорноговь аймаг дахь ШШГГ-ын 2020.02.19-ний өдрийн 01/195 тоот албан бичгийг үндэслэн данс бүртгэлээс хаасан байна.

## 2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 216.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 267.3 сая төгрөг болж, 50.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
----------	----------------	-----------------	-------

Тусгай зориулалттай материал	71.00	94.85	23.85
Эм боох материал	3.82	12.30	8.47
Бичиг хэргийн материал	10.75	19.97	9.22
Аж ахуйн материал	50.45	60.19	9.74
Сэлбэг хэрэгсэл	5.27	8.14	2.87
Түлш шатах тослох материал	25.76	21.44	(4.32)
Хүнсний материал	11.28	11.95	0.67
Бусад хангамжийн материал	12.16	12.16	-
Мал амьтад	26.29	26.29	-
<b>Дүн</b>	<b>216.78</b>	<b>267.28</b>	<b>50.51</b>

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа төсөвт байгууллагууд 379.5 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, УТХО болон ОНТХО, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 8.6 сая төгрөг, нийт 388.2 сая төгрөгийн бараа материал тус тус нэмэгдэж, 337.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан данс бүртгэлээс хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан материал байгаа бөгөөд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь 2019 онд тээвэр шатахууны зардлаас 24.2 сая төгрөгийн шатахуун, түлш халаалтын зардлаас 10.6 сая төгрөгийн түлш худалдан авахдаа ХАА зохион байгуулаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчсөн байна.

- Сумын ЗДТГ нь бараа материалын дансанд бүртгэлтэй 26,290.2 мянган төгрөгийн мал амьтныг нас дэвшүүлэн бүртгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээ, хөрөнгө оруулалт, авлага, бүх өр төлбөр, аж ахуйн ажиллагааны санхүүгийн эх үүсвэр, бүх орлого, бүх зардал, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлсийг заавал бүртгэнэ" гэж заасныг зөрчсөн байна.

- Сумын ЗДТГ-ын бараа материалын жилийн эцсийн тооллогын баримтыг шалгахад тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй, баримт бүрдэл хангалтгүй байна.

#### 2.8.4 Үндсэн хөрөнгө

Цэвэр үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,142.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,913.3 сая төгрөг болж, 229.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №.4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>3,942.00</b>	<b>3,712.68</b>	<b>(229.32)</b>
Барилга, байгууламж	2,847.85	3,240.49	392.64
Хуримтлагдсан элэгдэл	(15.60)	(732.81)	(717.21)
Авто тээврийн хэрэгсэл	304.10	322.87	18.77
Хуримтлагдсан элэгдэл	(202.37)	(219.57)	(17.21)
Машин тоног төхөөрөмж	386.11	459.63	73.52
Хуримтлагдсан элэгдэл	(237.49)	(280.33)	(42.84)
Тавилга, аж ахуйн эд хогшил	213.89	218.62	4.73
Хуримтлагдсан элэгдэл	(127.45)	(129.58)	(2.12)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5.29	5.29	-
Бусад үндсэн хөрөнгө	1,571.44	1,767.80	196.36

Хуримтлагдсан элэгдэл	(838.55)	(976.51)	(137.96)
Дуусаагүй барилга	-	-	-
Номын фонд	34.78	36.78	1.99
<b>Биет бу хөрөнгө</b>	<b>200.62</b>	<b>200.64</b>	<b>0.02</b>
Программ хангамж	3.31	3.51	0.20
Хуримтлагдсан элэгдэл	(3.07)	(3.25)	(0.18)
Бусад биет бус хөрөнгө	200.38	200.38	-
<b>Дүн</b>	<b>4,142.63</b>	<b>3,913.32</b>	<b>(229.30)</b>

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа төсөвт байгууллагууд 55.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэж, УТХО болон ОНТХО, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 683.9 сая төгрөг, нийт 738.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус нэмэгдэж, 50.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу актлан данс бүртгэлээс хассан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь 2019 онд Ай-Ти-Зоне ХХК-аас нийт 12.8 сая төгрөгийн 9 ширхэг зөөврийн компьютерыг шууд худалдан авч, үнийг 3 хуваан шилжүүлсэн байна. Энэ нь ХАА-тай холбоотой хууль тогтоомжийг зөрчсөн байна.

- Сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын баримтыг шалгахад тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй, баримт бүрдэл хангалтгүй байна. Учир нь тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон ч тооллогын хугацаанд хэрхэн тоолсон, ямар шийдвэр гарсан, хөрөнгө дутагдсан болон тохирсон эсэх, хурлаар асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн зэргийг нотлох боломжгүй байна.

#### 2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1.4 сая төгрөг болж, 13.7 сая төгрөгөөр буюу 90.8 хувиар буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<u>Ажиллагсадтай холбогдсон өглөг</u>	0.45	0.23	(0.22)	49.36
<u>Байгууллагат төлөх өглөг</u>	14.63	-	(14.63)	100.00
<u>Хувь хүмүүст төлөх өглөг</u>	0.05	1.16	1.11	2,296.77
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>15.13</b>	<b>1.39</b>	<b>(13.74)</b>	<b>90.82</b>

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.4 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой болон байгууллагад төлөх өр төлбөр 14.8 сая төгрөгөөр буурч, хувь хүмүүст төлөх өр төлбөр 1.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь шалтгаалсан байна.

#### 2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Цэвэр хөрөнгө өмчийн дансны эхний үлдэгдэл 4,583.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,420.3 сая төгрөг болж, 163.2 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /ЗГсан/ орон нутгийн сан	2,284.10	2,284.10	-	-
Өмч:Төрийн өмч	2,284.10	2,284.10	-	-
Хуримтлагдсан үр дүн	1,477.37	1,314.49	(162.89)	11.03
Өмнөх үеийн үр дүн	1,477.37	1,487.07	9.69	0.66
Тайлант үеийн үр дүн	-	(172.58)	(172.58)	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	822.02	821.75	(0.28)	0.03
<b>Дүн</b>	<b>4,583.50</b>	<b>4,420.34</b>	<b>(163.16)</b>	<b>3.56</b>

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа 5 төсөвт байгууллагад нийт 9.7 сая төгрөгийн НББ-ын бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдсэн нь олон жилийн насжилттай авлага, өр төлбөрийг Дорноговь аймаг дахь ШШГГ-ын 2020.02.19-ний өдрийн 01/195 тоот албан бичгээр 4.6 сая төгрөгийн авлага, сумын ЗДТГ-ын 2020.01.05-ны өдрийн А/03-р тушаалыг үндэслэн 14.0 сая төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлээс хассан, мөн 0.3 сая төгрөгийн дахин үнэлгээтэй хөрөнгийг акталсан нь нөлөөлсөн байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2018 оны 11/03, 2019 оны 1/09-р тогтоолуудад орон нутгийн төсөвт төвлөрүүлэх сумын татварын болон татварын бус орлогыг 246.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 267.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 8.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /дутуу -, илүү + /	Хувь
Үйл ажиллагааны орлогын татвар	25.00	24.16	(0.84)	(3.4)
Бусад орлогын татвар /Хувь хүнээс суутгасан ОАТ	50.00	66.32	16.32	32.6
Хадгаламж хүү	25.00	35.00	10.00	40.0
ҮХХ борлуулсны орлого	0.25	0.10	(0.15)	(60.0)
Бууны татвар	4.00	2.54	(1.46)	(36.4)
УТХураамж	1.45	8.61	7.15	493.2
Хог хаягдлын хураамж	17.05	4.56	(12.49)	(73.3)
Агнуурын нөөц ашиг/төлбөр, ан амьтан агнах барих зөв/хураамж	26.95	29.65	2.70	10.0
ТТАМАТөлбөр	73.00	69.06	(3.94)	(5.4)
Хүү, торгууль/	24.00	27.57	3.57	14.9
<b>Татварын болон татварын бус орлогын дүн</b>	<b>246.70</b>	<b>267.56</b>	<b>20.85</b>	<b>8.5</b>

Сумын татварын болон татварын бус орлого 20.8 сая төгрөгөөр давж биелэхэд:

- Бусад орлогын татвар 16.3 сая төгрөгөөр давсан нь Ноосны урамшууллын 10%-ийн суутгал мөн ханги хилийн боомтод хураагдсан махыг худалдан борлуулсан зэрэг төлөвлөөгүй орлого орсноос

- Хүүгийн орлогын татвар 10.0 сая төгрөгөөр давсан нь иргэдийн хадгаламж өссөн
- Улсын тэмдэгтийн хураамж 7.1 сая төгрөгөөр давсан нь ангийн төлбөрийн төлөвлөөгүй орлого орсноос
- ААНАТ болон хүү торгуулийн орлого 6.3 сая төгрөгөөр тус тус давсан нь валютын ханш өссөн, зөрчил гаргасан жолоочийн тоо их байсан зэрэг нь шалтгаалсан бол
- Үйл ажиллагааны орлогын татвар 0.8 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 0.1 сая төгрөг, хог хаягдлын хураамж 12.5 сая төгрөг, бууны татвар болон ТТАМАТ 5.4 сая төгрөгөөр тус тус тасалдсан нь үл хөдлөх хөрөнгө борлуулалт буурсан, ТТАМАТ төлдөг компанийн үйл ажиллагаа зогссон, хог хаягдлын хураамжийн тасралт нь ханги хилийн боомтын тээвэрлэлтийн компаниуд төлбөрийг дутуу төлсөн, буутай иргэд буугаа хоорондоо зарсан, эцсийн эзэмшигч нь олдохгүй маргаантай бууны татварыг дутуу төвлөрсөн, үйл ажиллагааны орлогын татварын бууралтад ханги хилийн боомтын бизнес эрхлэгчдийн тоо буурсан зэрэг нь тус тус нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 2,405.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,993.0 сая төгрөгийг урсгал зардалд, 412.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 649.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,146.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 29.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 412.2 сая төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээс, 168.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 09/08 дугаар тогтоолоор суманд олгох татаас санхүүжилтийг 309.4 сая төгрөгөөр баталсныг 2019 оны 11/09, 12/07 дугаар тогтоолоор 11.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 320.6 сая төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна.

Нөхөн сэргээх сангийн 9.5 сая төгрөгийн орлого, сумын ЗДТГ-ын 2.1 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн гүйцэтгэлийн тайланд урд оны үлдэгдлээс санхүүжих дансанд төлөвлөж өгсөн байна.

Гүйцэтгэлээр 649.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,146.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 17.8 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 412.2 сая төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээс, нийт 2,225.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 11.7 сая төгрөгийг санхүүжилтийг дутуу авсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын 107.2 сая төгрөг нь батлагдсан төсвөөс 60.8 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны орлого 1.2 сая төгрөгөөр давж, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 57.5 сая төгрөгөөр нөхөн сэргээх сангийн орлого 4.4 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,296.5 сая төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь урсгал зардлын зардлын гүйцэтгэл 1,889.9 сая төгрөг буюу 103.1 сая төгрөгийн хэмнэлттэй, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 406.6 сая төгрөг буюу 5.5 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан нь шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардлын гүйцэтгэл 1,308.8 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний зардлын гүйцэтгэл 558.5 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 22.6 сая төгрөгийг зарцуулсан нь шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 17 төсөл, арга хэмжээнд 412.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 412.2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, төлөвлөсөн төсөл арга хэмжээнд 406.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Жилийн эцэст сумын татварын болон татварын бус орлогын 20.8 сая төгрөгийн давсан орлого, урсгал зардлын хэмнэлт 2.8 сая төгрөг, нийт 23.6 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 2 байгууллагад 17.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын хүрээнд 4 байгууллага 154.5 сая төгрөг, нийт 171.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нийт санхүүжилтийн зарцуулах эрхийг зохих журмын дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээр нээлгэн холбогдох бараа үйлчилгээний зардалд 164.4 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 2.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 4.7 сая төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5, 3.6-д харуулав.

## **2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ТТЗ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

## **2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

## **2.13. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Хязгаарлалттай” дүгнэлт**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэл тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>456,008.17</b>	<b>508,406.94</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>69,906.37</b>	<b>109,962.36</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>69,906.37</b>	<b>109,962.36</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>69,906.37</b>	<b>109,962.36</b>
31211	Төрийн сангийн харилцах	69,870.37	109,962.36
31213	Арилжааны банк дахь харилцах	36.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>169,322.92</b>	<b>131,159.98</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	37.64	0.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,512.06	0.00
33400	Зээлийн хүүгийн авлага	6,088.00	6,088.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>17,733.82</b>	<b>8,234.55</b>
